



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар A/133

Улаанбаатар хот

**Иргэдэд газар эзэмших эрх
олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, 52 дугаар зүйлийн 52.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны A/77 дугаар захирамж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны A/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинээр газар эзэмших хүсэлт ирүүлсэн 4 (Дөрвөн) иргэнд өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмших эрхийг олгож, хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмших эрх олгогдсон иргэдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, Улсын бүртгэлд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3.Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, газрыг зориулалтын дагуу зөв зохистой эзэмшихийг хавсралтад нэр заагдсан иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД